

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр

ТУЗТ 07/2020

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Охин компанийн үйл ажиллагааны чиглэлийг
өөрчилж, хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдүүлэх
тухай

Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.6 дэх хэсгүүд, “Хар хорум пропертийс” ХК (“Компани”)-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.10.7, 10.10.8 дах хэсгүүд, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компани нь “Эрдэнэс рийл эстэйт” охин компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар өөрчилсүгэй . Үүнд:
 - a. үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааг зуучлах;
 - b. үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааг зуучлах;
 - c. үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ;
 - d. үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ.
2. “Эрдэнэс рийл эстэйт” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг 1 /нэг/ ширхэг нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 20’000’000 /хорин сая/ төгрөгийн үнэ бүхий энгийн хувьцаагаар нэмэгдүүлсүгэй.
3. “Эрдэнэс рийл эстэйт” ХХК-ийн дүрмийг энэхүү тогтоолын 1-р хавсралтаар баталсугай.
4. “Эрдэнэс рийл эстэйт” ХХК-ийг Санхүүгийн зохицуулах хорооноос үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдсон зардлыг Компани хариуцахыг дурдсугай.
5. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх болон Санхүүгийн зохицуулах хороонд эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авах, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон холбогдох татварын албанд өөрчлөлт хийх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/